




## МЕЛТЕМ агааржуулалтын бүрэн төгс шийдэл



“ Пи Эс Си “ ХХК

Хан Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн төвийн бүс,  
ХД Гудамж-388В, Улаанбаатар - 210136, Монгол Улс

Утас: 976 5088 4584, Факс: 976 5088 4585 Гар утас: 976 9909 1700

Вэб сайт: [www.dezentral.info](http://www.dezentral.info), И-мэйл: [pufe@psc-mongolia.com](mailto:pufe@psc-mongolia.com)



## МЕЛТЕМ агааржуулалтын бүрэн төгс шийдэл

### Агааржуулалтын талаарх сонирхолтой мэдээлэл

Та үүнийг мэдэх үү...

- Хүмүүс амьдралынхаа 90%-ийг барилга, байшин дотор өнгөрөөдөг.
- Хүн өдөрт 20,000 литр агаараар амьсгалдаг бөгөөд хамгийн багадаа цаг тутам 20 куб метр (DIN (EN) 1946) цэвэр агаар шаарддаг.
- 4 ам бүлтэй нэг өрх хоол унд хийх, угааж цэвэрлэх, амьсгалах зэрэг үйлдлээр өдөр бүр 10 литр усыг уур хэлбэрээр гаргаж байдаг.
- Өдөр бүр та гэр орноо тогтмол агааржуулж, чийгийг гадагшлуулах шаардлагатай. Түүнчлэн тамхины утаа, барилгын материал, тавилга, хивс, хивсэнцэрээс ялгардаг хортой бодис, тоос тоосонцорыг зайлуулж байх хэрэгтэй
- Өвлийн цагт цонхонд бага зэргийн завсар гаргахад л гаднаас орж ирсэн агаарыг халаах байдлаар дулааны эрчим хүчийг алдаж эхэлдэг. (мөн манай нөхцөлд цэвэр агаарын оронд CO<sub>2</sub>, янз бүрийн угаар, дутуу шаталтын эсэл зэрэг нь цонхоор орж байна )
- Мелтем нь өрөөг цэвэр агаартай, тав тухтай байлган, дулааны үр ашгийг нэмэгдүүлж, агаар солилцоог идэвхжүүлэх дэвшилтэт технологийн шийдлийг боловсруулж гаргасан байна

### Цэвэр агаар эрүүл энхийн үндэс

Барилга байшин бүр төгс байршилтай байж чаддаггүй шүү дээ. Гадна орчны чимээ шуугиан тав тухыг тань алдагдуулахаас эмээж тэр болгон цонхоо нээлттэй байлгах боломжгүй байдаг. Харин Мелтемиг суурилуулснаар агаар оруулж гаргахад цонхтой харьцуулбал маш бага зай буюу 10 см-ын диаметртэй хоёр хоолой байхад л хангалттай.

Барилгын хана баригдаж дууссаны дараа тэнд мянга мянган литр чийг хуримтлагдсан байх бөгөөд 2-3 жил тогтмол агаар солилцоо хийгдэж байж энэ их чийгийг гадагшлуулдаг бол энэ хугацааг хэдхэн сар болгон наашлуулж болох нь. Түүнчлэн хүмүүсийн амьсгалах, хоол унд хийх, угаалга цэвэрлэгээ хийх зэрэгт ялгардаг чийг уурыг мөн арилгаснаар үүнээс шалтгаалан барилга байшинд мөөгөнцөр үүсэх ба учруулж болзошгүй аливаа гэмтлээс урьдчилан сэргийлдэг.

Төвлөрсөн агааржуулалтын системийн үед агаарыг тодорхой байршилд аваачихдаа агааржуулалтын хоолойг ашигладаг. Энэ нь харьцангуй өртөг өндөртэй мөн тухайн шугам хоолойнуудын арчилгаа цэвэрлэгээ гээд эрүүл ахуйн нөхцлийн хувьд эргэлзээтэй асуудлууд нээлттэй хэвээр үлддэг билээ.

Агаарыг тодорхой байршил руу аваачихад ашиглагддаг хоёр сэнс хэчнээн цахилгаан эрчим хүч хэрэглэдэг болохыг мэдмээр байгаа биз дээ. Мелтемийн нэг төхөөрөмж 30м<sup>3</sup> агаарыг нэг цагт сэлгэнэ гэж тооцвол энэ хоёр сэнс нийлээд ердөө л 5.2 Ватт орчим цахилгаан хэрэглэдэг байна. Түүнчлэн төвлөрсөн агааржуулалтын системийн үед агаарыг хэчнээн метр хоолойгоор дамжуулдаг билээ дээ, харин энэ төхөөрөмжийг суурилуулснаар барилгын гадна ханын зузааныг давахад л болно. Гадна орчны температур бага байх тусам Мелтем төхөөрөмжийн дулааны алдагдлыг нөхөх ажиллагаа улам идэвхждэг.

“ Пи Эс Си “ ХХК


Хан Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн төвийн бүс,  
ХД Гудамж-388В, Улаанбаатар - 210136, Монгол Улс  
Утас: 976 5088 4584, Факс: 976 5088 4585 Гар утас: 976 9909 1700  
Вэб сайт: [www.dezentral.info](http://www.dezentral.info), И-мэйл: [puije@psc-mongolia.com](mailto:puije@psc-mongolia.com)




## МЕЛТЕМ агааржуулалтын бүрэн төгс шийдэл

### Мэлтэмийн давуу талууд


- Их хэмжээний чийг хуримтлагдснаас барилгад учруулж болох гэмтлээс хамгаална
- Цэвэр агаараар амьсгалахын сацуу дулааны алдагдлыг нөхнө
- Харшилтай хүмүүс өрөөндөө хамгаалалттай тайван байх боломж
- Тамхины утаа, хивс хивсэнцэр, тавилга эд хогшилоос гардаг тоосонцор, хог шороо зэргээс бохирдсон агаарыг зайлуулах
- Гадна орчны чимээ шуугиангүй тайван тухтай хэлбэрээр агаар солилцоо явагдана
- Дулааны алдагдлыг хэмнэнэ
- Нүүрсхүчлийн хийг бууруулна
- Төвлөрсөн системийг бодвол өртөг маш багатай
- Суурилуулахад энгийн хялбар
- Германы Техникийн мэргэжлийн хяналтын газраас туршиж, баталгаажуулсан



Агаар солилцооны бүдүүвч.



Төхөөрөмжийн дотоод эд анги.



Харагдах байдал.

### Мэлтэм хэрэглээний олон төрлийг санал болгож байна

Нэг өрхийн хаус, пентхаус, олон давхар барилга орон сууц, хуучны байшинг сэргээн ашиглах, дуу чимээ тусгаарлах шаардлага бүхий барилга, байшин, тэдгээрийн өрөөнүүд г.м **айл өрхийн хэрэгцээнд**

Хүүхэд хөгшдийн асрамжийн газар, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд, бүжиг, иога, фитнесийн заал, оффисийн барилга гэх мэт **худалдаа, үйлчилгээний компани, төрийн байгууллагын хэрэгцээнд**

### Хамгийн үр ашигтай дэвшилтэд технологи - Орон сууцны агааржуулалтын систем

Өрөөн доторх бохир агаарыг гадагшлуулах, цэвэр агаараар өрөөг хангах зорилгоор дулааны алдагдлыг нөхөгч Meltem агааржуулалтын системийг бүтээсэн. Энэ нь хананд суурилуулдаг төхөөрөмж учраас агааржуулалтын хоолой шаардлагагүй. Энэ систем нь цонхнууд хаалттай үед ч температурын хяналт бүхий цэвэр агаараар байнга өрөөг хангадаг. Агааржуулалтын түвшинг өрөө бүртээ тохируулан сонгох боломжтой. Өрөөний агаарыг 2 цагийн дотор бүрэн цэвэршүүлж дуусдаг.

### Мэлтэмийн талаар зарим нэг хэрэглэгчээс ирсэн асуулт

Асуулт 1. Хэрэглэгч: - Өрөө бүрт Мелтем агааржуулах төхөөрөмжийг суурилуулах хэрэгтэй юү?

Мэлтэм: - Төвлөрсөн бус систем учраас өрөө бүрт суурилуулбал зохимжтой. Гэхдээ бүх өрөөнд заавал суурилуулах шаардлагагүй, зочны, унтлагын, хүүхдийн болон ажлын өрөөнд суурилуулахыг зөвлөж байна.

Асуулт 2. Хэрэглэгч: - Нэг айлын хауст хэчнээн Мелтем агааржуулалтын төхөөрөмж шаардлагатай вэ?

“ Пи Эс Си “ ХХК

Хан Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн төвийн бүс,  
ХД Гудамж-388В, Улаанбаатар - 210136, Монгол Улс  
Утас: 976 5088 4584, Факс: 976 5088 4585 Гар утас: 976 9909 1700  
Вэб сайт: [www.dezentral.info](http://www.dezentral.info), И-мэйл: [puije@psc-mongolia.com](mailto:puije@psc-mongolia.com)



## МЕЛТЕМ агааржуулалтын бүрэн төгс шийдэл

Мэлтэм: - Суурилуулах төхөөрөмжийн тоо нь өрөөний хэмжээ, тооноос хамаарна. Гэхдээ 30-40м<sup>2</sup> талбайд нэг төхөөрөмж байхаар ойролцоогоор тооцоолж болно.

Асуулт 3. Хэрэглэгч: - Мелтем агааржуулах төхөөрөмж нь өөрөө хэр чимээ гаргадаг вэ?

Мэлтэм: - Хамгийн энгийн тохиргоо буюу цагт 15м<sup>3</sup> агаар солилцоо хийхээр тохируулсан байгаа үед 15.5 дицбалл буюу бараг ямар ч чимээ гаргахгүй ажилладаг гэсэн үг. Үүнийг бусад дуу чимээтэй жишиж харьцуулбал цагны цохилох чимээ 20db, хүмүүс хоорондын яриа 50 db байдаг байна.



Өрөөн дотор харагдах байдал.



Гадна талаас харагдах байдал